

## БҮҮВЭЙ БЭЙЛИЙН СУДАР ХЭМЭЭХ СУРВАЛЖИЙН ТАНИЛЦУУЛГА

Цонгоол Б.НАЦАГДОРЖ

**Товч агуулга:** Монгол улсын Үндэсний номын сангийн монгол гар бичмэл номын хөмрөгт хадгалагдаж буй “Бүүвэй бэйлийн судар” хэмээх сурвалжийн агуулга нь хори буриадын түүхэнд холбогдоно. Сурвалжид гарах үйл явдал, түүний дараалал сэлтийг үзвэл, хэдийн хэвлэгдсэн “Балжин хатны домог” хэмээх сурвалжийн нэгэн хувилбар боловч түүнд байхгүй өөр мэдээ сэлт бүхий, хэлний хувьд найруулга нь өөр байдалтай байна. Иймд энэхүү сурвалжтай холбоотой Үндэсний номын сангийн хөмрөгт хадгалагдаж буй Бүүвэй бэйлийн судар хэмээх сурвалжийг галиглан хөрвүүлж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулахаар танилцуулж байна.

**Түлхүүр үг:** Үндэсний Номын сан, гар бичмэл, Бүүвэй бэйлийн судар, Балжин хатны домог

### Оршил

Буриадын түүхэн сурвалжийг цуглуулж эмхтгэн, эрдэм шинжилгээний тайлбар хийж, уг монгол эхийг орос орчуулгын хамтаар хэвлүүлэх ажлыг өнгөрсөн зууны 30-аадоноос эхлэн Зөвлөлтийн эрдэмтэд хийж гүйцэтгэсээр эдүгээ болоход буриадын нутаг бүрийн түүхэнд холбогдол бүхий 30 шахам их, бага хэмжээтэй сурвалжууд илэрч мэдэгдээд бий. Үүнээс уг сурвалжуудын факсимиле эхийг хэвлэсэн нэг ч тохиолдол байхгүй, харин ч сүүлийн үе болоход гол төлөв орчин цагийн буриад аялгуунд хөрвүүлж, мөн зөвхөн оросоор орчуулан нийтлүүлж байгаа зэргээс эрдэм шинжилгээний жинхэнэ эх бичгийн судалгаа дутагдсаар байна.

Доор танилцуулах “Бүүвэй бэйлийн судар” хэмээх сурвалж нь Монгол улсын Үндэсний номын сангийн монгол гар бичмэл номын хөмрөгт 67/96 9(517.3) Б 905 дансны дугаартай хадгалагдаж буй бөгөөдагуулга нь хори буриадын түүхэнд холбогдоно. Сурвалжид гарах үйл явдал, түүний дараалал сэлтийг үзвэл анх Оросын монголч А.М.Позднеев “Монголын утга зохиолын дээжис”-тээ монголоор хэвлүүлсэн “Балжин хатны домог”<sup>1</sup> хэмээх сурвалжтай төстэй уг сурвалжийн нэгэн хувилбар боловч түүнд байхгүй өөр мэдээ сэлт бүхий, хэлний хувьд найруулга нь өөр байдалтай байна. Өмнөх үеийн судлаачид тус “Балжин хатны домог” сурвалжийг хори буриадын анхны түүхэн сурвалж гэж үзсээр

<sup>1</sup> Позднеев, А.М. *Монгольская хрестоматия для первоначального преподавания*, Санкт-Петербург, 1900, 47-55.

иржээ.<sup>2</sup> Иймд энэхүү сурвалжтай холбоотой Үндэсний номын сангийн хөмрөгт хадгалагдаж буй Бүүвэй бэйлийн судар хэмээх сурвалжийг галиглан хөрвүүлж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулахаар танилцуулж байна.

Уг сурвалжийн тэргүүн нүүрэнд Монгол улсын судар бичгийн хүрээлэнгийн номын сангийн Азийн тасгийн тамга дарагдсан байдлаас үзвэл, Судар бичгийн хүрээлэнгийн цуглуулганаас Үндэсний номын санд уламжилж ирсэн бололтой. Тус сурвалжийг сударчилсан хэлбэртэй орос цаасан дээр ар өвөргүй төмөр үзгээр бичсэн нийт 15 хуудас бөгөөд нэгдүгээр нүүр хуудасны арын нүүрээс эхлэн хуудас бүрийг монголоор дугаарлажээ. Хожим хөх өнгөтэй хавтас үйлдсэн хүн буриад бичгийн хэвийг тод үсэгтэй андуурч, “Тод үсгийн” гэж нэмж бичсэнээ балласан байдал тодорхой мэдэгдэж байна. Ерөнхий бичлэгийн хэв нь буриадалбан бичгийн хэвтэй бөгөөд монгол бичгийн хэлзүйн дүрмийг тэр бүр сахиагүй, зарим үсгийг хутгасан буюу галигт хэрэглэдэг үсгийг хэрэглэсэн зүйл ажиглагдаж байна. Тус хуулбарын үндэс болгосон уг эх нь нилээд хуучин эх байсан бололтой, зарим газар буруу хуулсан зүйлийг сүүлд нэмж зассан зүйл нь хуучин хулсан үзгийн бичлэгийн хэвтэй бичигджээ.

## 1. Галиг

todu üsüg-ün bübei bevelü qayan-u sudur orošiba.

büübei bevelü qayan-u sudur orčiba

nige

erte nigen čay tur jegün urida / dorn-a emün-e-yin jobkis-dur keüken / gegen-ü oron-ača jegün jüg-dür solngyud / -un büübei bevelü bayatur gegči bayıgsan / modu-yi quyu dariqu dayariqu, / bayıgsan čılayu-yi kemker-e gesgigülkü / turıyuti, qan külüg moriti, qar / čayan-ni yazar-tu bayıgsan teke / görügesün-ü niruıyui-yi örüm jebe / -ber ququ qarbaru alagsan, qorin / sürüg görgüsün-eče ere ingzay-a / em ingzay-a qoyari üldegejü / alday teyimü mergen kümün aysan / ajiyu, tere kümün yabun / atala nigen bulag-un ekin-eče / küler buu oluyad, keüken gegen / -dü ayıladqaysan-du ši kemebesü / qayan bolqu yosotoi aysan / tula, ene činu luus-un / qayan-u qačıbuva tamı-a učırba. / qayan bolutuyai gebe. teyin qayan / boluyad, nigen jil-ün jıruyan / qonoy-du širge daruju sayuyad

qoyar

^ busu edür-e-ni abal-ju yabuqu / aysan ajiyu. teyin bayi-ju / qayan bolba. albatu – / qariyatu minu amarjiba kemejü / tere qayan nige qatun-ača / dai qung tayiji kemekü köbegüti / aysan-ıyan keüken gegen-dür / mörgügülkü gejü nayıman jayun / albatu-ti, nayıman jayun / qatun keüked-ti, nayıman / ayımay duıyti (tuy-tai) öber-e morduju / yabun kürbe. kürüged nayıman / jayun keüked anu, nayıman / kümün metü bolju, nayıman / tuy-ıyan qadquba. nayıman / jayun mori-ıyan tabıqu anu, / nayıman jayun kümün usu / ačarqu, yal tülkü ba ali / yabudal anu nayıman kümün / ^ metü yabuqu

<sup>2</sup> Цыдендамбаев, Ц.Б. *Бурятские исторические хроники и родословные*. Улан-Удэ, 2001, 42.

ajiyu. / qoyitu nayiman jayun abčin / anu aliba ang görgesü / alju nayan soyqu-a alju / ireged mön urdu yosuyar / bayuba. nayan soyqu-a-ban / gegen-dür ergüjü mörgübe / mörgüküyin çay-dur anu. / gegen jarliy bolba. yurban / qonuy-tu tanu algsan ang / -yi nigül kilinçe arilyaqu. / yurba qonuyad basu irejü / mörgütügei gebe. yurban / qonuyad mörgükü-degen / qatun keüked anu eldeb / öngge-yin ed toryo nutuy-aça / gegen-ü süm-e kürtele debçijü / tegün-ni gešigen / irjü mörgübe. adis / abaju mendü amur kermen

yurban

^ yarba. nayiman jayun abačin / büübei bevelü terigülen bugedüger / irejü mörgüküi-degen jarim / anu, yosuyar mörgüjü jarim / anu bi ečebei, ebedbe / çilebe kememüi. çii ker bayimui / kermen bey-e bey-e ečegen asaýulčaba. / teyin mörgüjü bayitala büübei / bevelü ayiladqaba jegün urida / jüg-dür čerig-tü mordoqu / belei bida man-dur sakiyusu / jalju qayir-a boltuyai kermen / erin ayiladqaba. tus tus / -tur ni sakiyusu bičijü / bayitala, nigen jayuyad / kümün anu, sakiyusu / abčiu bayitala küliyejü / yadayad ene bada-tur ču / sakiyusu yaçu čidabai gejü / keleged mortoju qariju / irebe. ger-tegen ireged / ^ nigen doloğan sakiyusu-yi / doloğan yamağan-dur jegüged / tere doloğan yamağ-a-yi / doloğan kümün kümüsen namnaju / ireji qarba: doloğ-a / doloğ-a qarbutula ese / dayagdaba ene yeke adis / -tid-tü sakiyusu kümün / nige nigen quudusu<sup>bar</sup> qubiyaju / nayiman jayun kümün jegüji / čerig-tü mordoba. / mordoju očital-a qonogči-yin / yazar kürekü-tü usun anu. / qorqoyitoi aysan tula / bey-e morin ügei yadaju / ayuju yadaba tere usun / -u činadu utuy-a yarču / očin geküdü qaşas qas bey-e / -ti ulus bayiba ajiyu. / tegün ni qarba ju sabčiju / ese dayalyabai. qoyar jayuyad / anu, ükjü busuju

dörben

^ irbe. teyin sayutala / anu barayun jüg-eče sayaday / -tui kemekü qubilyan blam-a irebe. / tegün-tü ayiladqagsan-du ertü / -tü keüken gegen-ü jalagsan sakiyusu / -yi čergegeju jasaji ögbe ene / sakiyusu-ban ebdegsen tula / ta-a ese čidaba ali jüg / -tü aysan bolba kemeküdü qola / bile: bida ese medebe gebe: / sayaday-tu qubilyan tede / tanu ene ger-ün qoyina bayina / kermen nigen kümün-i ene tačiyur / bariju yarayad sürtel ügei / abčiu ire gebe. tere / kümün abčiu iregši ger-dü / orşulba. tere qubilyan nom / nomloji tede büküli bey-e-ti / bolşoju bayigsan yajar-dur / anu ilgebe. tede busu / qağan-u turčiyul gejü / ^ jarliy bolba. tere yajar / -du qour ni ügei bolba. / ta-a demei qari qağan luğ-a / büü dayilaldu kermen jarliy bolju / ögödü bolun qariba. teyin / bayital-a dai qung-dayiji-du / qatun bedirjü urda jüg / mordoju çayan luus-un qağan / -aça utay-a-du bürileng kemekü / ulus-dur kürejü beri-yi / kelelčeju tede-ni uriju iregsen / ajiyu. tede ni irejü yeke / nayir nayadan kiji / bayiji beri-ben bayulyaba. / büübei bevelü ečige anu. / dai qung tayiji dayan / arban otoy ulus engji / ögbe. tere qağan-u qatun / anu nasun-aça ögödü / bolba dalan dörben nasu / -ti ečige qağan busu nigen

tabun

^ qatun abuba. dai qung tayiji / -yin baljin qatun nökur-degen / kelebe çii nigen qatun / luğ-a eyikü nayadaqu činu / engküren bayinam çii samuyuu / mayuu-bar yabunam biu ši / gebe. tegüneče eke beri / qoyar yeke kergültili / bolju, dai qung tayiji / negüjü onon-u uritu bey-e / -dü kökülbi-yin köbčidü / bayuba. tendü-ben / sayutal ni büübei

bevelü / -yin qatun qayan-dayan / kelen ayurlaba. ečige / anu köbegün-iyen medekü. / ere anu em-e-ben medekü. / yosotoi. šii qayan biu. / köbegün činu em-e-degen / medegdejü kökülbi-yin / - köbčide yarba gebe. / büübei bevelü ayurlaju / qoyar mingyan čerig-yi ilegebe. / baljin qatun-u barayun / köke-yi oytolju alayad. / toloyai-yi toloyai yazar / köl yari inu köl yar / metü yazar orki. qar-a / mori-yi inu nigen yol. / emegel-i busu yazar: / togyu-a-yi busu yazar / orkiyod: dai qung tayiji / -yi albatu-ti ni abčiu / irgejü elgebe: tere / qoyar mingyan čerig-üd / očijiu dayilaqui-dur: / baljin qatun arban / yurban qubilyan-ti / aysan tula čayibar / čisüdü qubilaju ese

jiruyan

^ oldoba: albatu-yi anu / abučaiqu bolqudu baljin / qatun usun-ača öber-e / yarčiu ireged kelbe: ta-a / ečige qayan-u jarliy-iyar / boluytun gebe: bi ečige-yin / jarliy-ača ülü dabaqu aysan / tula čidaqu bolbaču bi / sayuji ükümüi gebe: / barayun köke-yi anu / oytolju alba: toroyin / ekin-dü alagsan ajiyu / qayan-u jarliy-iyar yazar / bügüdü qubiyaju orkiba. / toloyoi-yi anu baljin-a / -yin nayur-ača urida / jüg-dür nigen toloyoi / -du orkiba: mori anu / borji-yin ekin-ü jegün / bey-e-dü orkiba. / baljin-a-yin qar mori / -tu kemekü yol bolba. / ^ teyin tere čerig / -üd dai qung tayiji / -yin qoyar mingyan arban / omoç albatu-yi abučaiju / büübei bevelü-dür tučiyaba. / dai qung tayiji gegen-dür / ayiladqaba: burqan-u sijin / ni naran metü mandayulayči / gegen-ten: qayan-u / törü-yi barigčii ečige / minu: anu minu yabudal / yayun belei gebe: gegen / jarliy bolba: ečige / qayan-i boliyulqu dai / qung tayiji-yi sirge / darutuyai geküdü köbügün / anu kelbe ečige minu / sirge-ben darutuyai: / bi ködögödü sayuju / nüngnei sakisu gebe: / gegegen jöb / kemejü ečige qayan /

dolon

^ sirge-degen sayuba. / köbögün anu nüngnei / sakiba: sakiyu-dayan / 11 ečige albatu minu / terigün dü kürkü čay-du / üre-ber büü tasartuyai: / törü-dü kürkü čisun-du / öuke-ber büü tačartuyai. / nigen čay-du blam-a-yin / törül olju: tan-dayan / öngdür aqu. ergün sijin / delgejü nom nomlaqu minu / boltuyai kemen irügül / irügebe: tede arban / otoç albatu anu: tengdü / -ben bayin atala büübei / bevelü qayan dayan duran / ügei aysan tuldu: / inagči sinagči-ban yabuju / yabuqu anu: bögütür / qar uliyad-ud yeke / qorloju alba: teyin / bayital-a arban otoç / ^ ulus-ača jarim otoç / -ača yekengki anu inagči / irejü: jarim-ud anu / bayangki anu qariju / irejü: tere čay-du / onon-u yol-du tüürge / bouji-yin adaç-du / booqoyi <sup>bo-o-qoi</sup> quvačai-yin / keki bökü böke gegči / doloy-a nasu-tai köbögün / -tei aysan ajiyu: / tere köbögün anu doloy-a / nasun-dayan noçai-bar / aluldaju arsu miq-a / -ban qaçara tatayul / -baču gem ügei yabuqu / teyimü bayatur kümün / aysan tula ni babaji / bars bayatur geji ner / -lebe: tere kümün yeke / tamkinči aysan tamki / tasaldaju bayital ni: / nige oros tamki qualdaju / irebe:

nayiman

^ abučayum-a ügei / aysan tula sula / ireküdu-ni ese ögübe / tere oros-un mordoju / očiqudu-ni tere bayatur / qoyina-ača getejü očiçod / yasu niryuubar qarbaru / alayad tamki-yi abuba. / ečige anu ene yajar / sayuju ülü boluqu kemen / ayuju negüüjü urda / jügdeki aq-a degüü / -degen očiba: teyin / bayital basu busu ulus / bi bayaji bars bayar-

tur / bi geju irin irin / bögütür qar uliyad-du / alagdaju bayiba: teyin / bayital-iyar keki bökü / sögürgeben nekejü mön / onon-du bayuba ečige / eke-tegen angnaju / yaqai alaju ögčü qoγoloi / anu tejiyejü bayiba. / - teyin bayital bayaji bars / bayatur nigen edür angnaγad / qoyar yaqai tengejü irkü / -dü-ni yučiγad uliyad / irged otoγ-yi anu bučalju / bayiji kelbe: onon ni / noroqu-a-yi üldikü. buyu / yabina geküdü bel bol / čimgütei buyu / sersür sokiy-a geju / irübe bida gebe: / bayaji bars bayatur kelbe: / minu arban salayatu bel / bol čimgütei ta-a buyu ügei / buyu naran-u yaltai-du / dayilalday-a kemen qarbaldaba. / bayaji bars bayatur / jebe-yin kürkü yajar-du / mori aldaqu ügei. sumun-ni / kürkü yajar-du kümün / aldaqu ügei teyimü mergen / bayatur aγsan aji yučin / uliyad qarbaba ese kürgebe. / baras bayatur qarbaba / segülči-yin kümün-eče qorin / qoyar ona dabaju qorin / qoyar kümün-i unayaba:

yisün

^ nayiman kümün ülejü du[ta]yaba: / dutayaqudu-ni yurban kümün-ü / mori-yi qarbaju abči künesü / abuyad teden-i nekejü güyičeged / kelbe: quva mori-yi minu köl / doγolan boltola qarba-ba ta / morin-u yala yangq-a ača geküdü / ni yurban mori emegel-tei-yi ögčiü / bida egün-eče qoyiči arban nigen / ečige tan-du qalayaqu ügei / bida-yin nere abču orotuγai / kemen tangyarilaba: tere nayiman / kümün busuju očiba tere / čay-du arban nigen ečige-yin / jaγun jiran saγaday ulus / bolju nirsiü-giin jiruyan-du / qori yučin mönggü alba / örgüji bayibai qudai-yin / em-e-yin köbügün ba-a-tan mergen / gegči soγqu-a sübegelidčü / qarba-ba arban tabun ečige / -tei yaršildan buliyalduγad: / soγqu-a-yi 61 numun-u yajar erüged / qamar-ni onoyγan tudaysan kümün abqu / gebe: arban tabun ečige / -yin kümün nigedčü ese / onuba: ba-a-qan mergen / qarbuju onuyad abuba / ^ tegün-eče ulum kergülti / bolju öglügen-ü ulayan / naran-du niršiü-giin čayan / toloγoi-du irekü / sayin er-e tanu irütügei / arban tabun ečige kemeγed / tarba: tere čay-tu arban / nigen ečige-yin jarim anu: / düngnü-ber dabay-a yaryaju / negüübe: bayaji baras bayatur / čayan toloγoi-du yaruqu / geju doturban mingdusun / quyaγ em-jijü yadayur temür / quyaγ ömüsγed yarba / jaγun yučiγad qamniγad / irejü bučalba arban tabun / ečige-yin čisutu silatan / quvu-a čisuči ulayan jebe / -ben dürüjü irebe / baras bayatur qarbaldaju / jaγun yučin kümün-eče / jirin kümün ülegdebe. / tede ulus kelelčebe / ene yaγča kümün-ni

arba

^ endeβen egerejü qonoyad öglüge / edür-e-ni angqaju yar-iyar bariju / alay-a kemeldüged qonuba öglüge / edür-ni bayaji baras bayatur quyaγ / duuly-a-ban jebe-degen qadqaju / emüsgejü orkiγad qoyar kümün / ni qoγor dumduγur mölkijü / yaruyad irbe: inagči üdü / yazar bügedüger negüüjü / irügsen ajiyu: tende-eče / qudurту nituy-laju bayiqu čay / -tu-ban: čayan ečige-yin / duuči quurši qoyar duulba: / manu yazar tataysan miqan / tabiγsan tabay metü bile: / ene yajar-un kümün šibar / toqu-a-tai šiγazangqai / ayay-a-tai mangγud gegči geju / dayulba: tere čay-tu / čičin qa-a- gegči oros / irügjü keki böke-tü / tamki uuyad ögčiü yaday-a / kötüljü yaraquduni: čayan / -u duuši sir-a ečitei qutuy-a / - bar qadquju alagsan gele: / teyikü čay-tu-ni: ene qayan-u / oron-du sayuqui-yi kelelčekü / geju yaday-a yaruγsan bile / bi: yaγun-du alba ta geju / keki böke uyilaba uyilayad: / ene yazar amur sayuju ülü / bolqu geju temeγe-tü kümün

/ temege-iyen tabiglaju: / qonin-iyen qosiyu baratata: / temege-iyen ebüdüg barayulju / barayun jüg-dü negüüjü / yabutata: baras bayatur / yurban qonoy-tu uqay-a / medege ügei yeke ebüdked / bosba: bosuyad kelebe ebür / yazar oroju nituyulaju ülü / boloku: ene yazar yurban / jil nituyulaju sayuy-a geju / sayuba: sayuyad selengge / -yi uruyudaju negüüjü / yabutal-a doni tayay tuluyсан / oros-i nigen qabčiyai-du

arban nige

Ş olan učiraju tüd geju / dayu yarumayču tedен-ü / kümün ükünem očiju üzeküi / -dür čisu-tai aji: arban / nigen ečige kelelčebe: ene / čayan qayan-du oroqu / geju yabun-a bida albatu / -yi büü samči: geküdüni / qorloqui-ban bayiba: / tede kelelčejü negüüjü iren / itangčayin ostoroyta arban / nigen ečige qar tuy-iyen / tabiju qayan-ača ečige-yin / nige tuy abču arban / nigen kümün-dü bariyulju / yurban jil boluyad: alba / ögčü bayıysan ajiyu. / tere alba ögčü bayıqu / -yin čay-dur / quvačai-yin toytor kemekü / ebügen südüne tütüne geju qoyar / köbügüü-tei ebür yazar / ^ barayun jüg say-a sakiju / gegedegsen ajiyu. tere / ebügen-ü qoyar / gegüd-eče ni törügsen / qoyar qunan anu yambarba / bui-du bayira moris-tu ese / yartaba: tere čay-tu / tegün tere berke mori-yi / abqu geju činaduki / mongyol anu yurba / qonuyad čerig irenem geju / sonosyad: qoyar köbügüd / -iyen aq-a degüü-degen / qudura ilgebe qoyar / moris-iyen unuju irbe: / iriged qoyar köbügün anu aq-a degüü-lüge / jolyoba. köbügüd anu / ireged kelbe: nige qonoy / -du yabuju iregsen aji / bida: yurba qonoyad čerig / ireküi-yi sonosuyad ečige / manu moris-iyen kelen-ü

arban qoyar

^ izayur-tu tebene qadquju / ebedčün morin metü bolyoju / bayıysan bile: tede mongyol-nud / tegün-i üzeju daruydaqu kemen / yeke bayasaju bayına belei / manu mor-daqu čay-tu tebene / -ben suyulju abuyad ilgegsen. / döni dumdu mordoba bida gebe: / tere ügen-dü quduru-yin / arban nigen ečige-yin ulus / jirad sayaday suylaju / jayuyad adayun-tu qartayana / -du degel emüsgeju emegel toquju / güyilgeded quduru-yin čayan / kötül-dü bayilyaba: teyin / atala yurban qonoyad tere / kötül-iyer mongyol čerig irbe: / tedен-ü emün-e-eče jayun ayta-yi / üldebe: yuči yučin kümün / qoyar jiq-a-ačani dab gebe: / teyküdü mongyol čerig / gedürge tergelbe: selengge / dalai-yin olam kürtele üldejü / dalai-yin olam-iyar yarču odba: / arban nigen ečige busaju / ^ iriged nituy-dayan qarayul / qaraju bayitala tursiyul / yabuysan ulus qaraba selengge / deger utay-a yarču bayıqui-yi / qarayad čeriglen ireju üjeküdü / qoyar gerged nige sogqu-a bariju / idij sayuna aji: / qosingyud-iyen suyun-dayan / amayilaju sayuba: ta yayun bile / geküdü südüne tütüne qoyar / -un gerged bile qoyar gegüd / -iyen unuju irigsen bile / bida: qoyar gegü-ben aldaju / orkiyad čerig-ün mör-iyer / očiytun geju ečige kelegsen / üge-ber iren geküdü manu / ene soyqu-a-y činu / barıgsan-i ideju bayına / bida gebe: südüne / tütüne qoyar eres tanu / engdü bayınam geju abču / iriged eres ber neyilede-gü / -ljü sayulyaba jiryen / sayuba: tere qoyar yeke

arban yurban

^ aba buyu-du ünege čino / bolun ali yeke-yi jon-ača yarçaju / ögkü aji:: arban nigen ečige / tere čay-tu oyıqan-du quduru / -du sayuqu aysan aji:: tere / čay-tu čayan čaya-

dai bayan / gegči narin dalai-yin nayur čay / -tu qusun urγ-a-yi γurba / kemjijü adayu-ban usulju / yabuba: teyin yabutal-a-ıyan / tere bayan nayıman gegüü-yi egüčelejü / oyıqon-u čilayun-u köngdei / -dü qadayałba: adayun anu / činu-du idegdekü tusum / kečig ügei bolju yeke üsügen / bolba: adayusun-u γarza-yi / nige üüči kümün-dü / üzel üzegülen geküde yeke / noyad-un süm-e-dü miq-a / qadaqalaγsan aji. čii tegüni / küng-düle gebe: nigen / böge-e kümün-ii učiraju / ülegsın γangča mori / -bar qadquur bariju / ^ mörgübe: tere böge onγyo / -ıyan oroyuluγad qar-a buur-a-yin / qarkiraqu büü üzegde qanan / uniyan-ni qangginaqu büü üzegde / qan sotu noyan gegči bi gejü / oroyulba: tegün-eče ulam / busud anu mörgül kijü / doγčın noyad-tu quva adayusu / -bar mörgübe. tende-eče / inagči-du mön quduru-du / irejü sayuba: oyıqon / gegči ayulan doγsın kü / kečegüü gejü iregsın aji: / teyin selengge-ber nituγlayısan / bölüge: tünğnü, üde / ayu inggidei-ber nituγlaba: / teyin bayital-a ezen qayan-ača / biodor iligči gün sa-a-buu / kemekü noyan irejü jiran / qoyar obuqu-a pa-a-riti / -yin tabın qasaγ bayıyulan / tabiba: teyin biodor / iligči obuqu-a tabıqu / čay-tu öber γajar

arban dörben

^ -un vangbunar: nige oros / -un bayın sigeküde kelbe: / yadaqu ügei böged nöbür / -degen ülü öggülčekü / γayaraqı ügei böged bayın / sigekü tanu γayu bui / gebe: fiodor eligči-yin / vangbunar-i / yeke boγoju keleküdü-ni: / vangbuna tanu üge-yi kümün / qaraju ülü boγo: gün / sa-a-buu kelbe: tere čay-tu / arban nigen ečige-dü / dörben siülengge kergem-ti / kümün bui aγsan aji: / teyin atala γalzud-un / boltıroy-un köbügün sido / gegči-yi biodor eligči / singijü qayan iγayur-tai yeke / sayıqan singjitei kümün aγsan / tulda-ni tayis-a-a kergem-ti / bolγoba: tegün-eče qoyıči / 11 ečige amur jıγyalang-tai /

^ bolju sayuγsan kemen erten-ü / ebüged ögüeldügsın bölüge: / tere čay-tu arban nigen / ečige-yin aqalaγči tayıš-a-a / šido jakiy-a ilgebe: ebür / γazar tasurju gegdegsın / arban nigen ečige-yin sildei / janggi gegči-dü: bida ene / γazar-ıyar obuqu-a kile / tabıju bayına bida: ta / inagči oroju iregtün gebe: / teyiküdü tünğnü gegči γajar / suγun-u örüglen: üde / gegči γajar tanu degel / örügesün qangsui metü γazar / bile: mori yadabasu yara-a / qar-yi abayačıju unu emegel / yadabasu altan emegel abayačıju / toqu gebe: biodor eligči / tegüni sonusayad jarlıg / bolba: yaru-a qar-a: altan / emegel gegči qoyar qada-yi / inagči oroyulju abtuγai / gegsın üge bisiü kemegeđ

arban tabun

^ vangbunar-tai yeke kelelčekü / yadaγad ene manu γazar gejü / altan emegel gegči-yin / öber-tü qonın čayan čilayun / -du bičig bičijü orkiba: / tere obuqu-a-ača činagči / jayun jiran modun-un γazar / aji tegüni edüge boltol-a / buliyaldagsayar bayıqu bisiü / ertetü yabugsi booqoi quvačai / -yin bayaji bars bayatur-un / ači üre edüge daldatu / -yin köbügün mergen bardu gegči / bölüge: qangdu-du ibang taš-a-a / -du bui: togtor-un ači ürü / edüge kürbi oyıbungdu-yin / doktor jegün quvačai nar bui / bisiü: erten-ü ebügüdün / bayıyulaγsan sisdar / tuusi tögüsbe / o ma-a ni bad mi hou / o ma-a ni bad mi hou



## 2. Хөрвүүлэг болон тайлбар

Бүүвэй бэйл хааны судар оршив

/1/ Эрт нэгэн цагт зүүн урд дорно өмнийн зовхист Хүүхэн гэгээний<sup>3</sup> орноос зүүн зүгт солонгудын<sup>4</sup> Бүүвэй бэйл баатар гэгч байсан модыг хуга дайрах, байсан чулууг хэмхэр гишгүүлэх туруутай хан хүлэг морьтой хар цагааны газарт байсан тэх гөрөөсний нурууг өрөм зэвээр хуга харваж алсан, хорин сүрэг гөрөөснөөс эр янзага, эм янзага хоёрыг үлдээж алдаг тийм мэргэн хүн асан ажгуу. Тэр хүн яван атал нэгэн булгийн эхнээс хүрэл буу<sup>5</sup> олоод Хүүхэн гэгээнд айлтгасанд: - Чи хэмээвээс хаан болох ёстой асан тул энэ чинь лусын хааны хасбуу тамга учрав. Хаан болтугай гэв. Тийн хаан болоод нэгэн жилийн зургаан хоногт ширээ дарж суугаад /2/ бус өдөр нь авалж явах асан ажгуу. Тийн байж хаан болов. Албат харьяат минь амаржив хэмээж тэр хаан нэг хатнаас Дай хунтайж<sup>6</sup> хэмээх хөвүүнтэй аснаа Хүүхэн гэгээнд мөргүүлэх гэж найман зуун албаттай, найман зуун хатан хүүхэдтэй, найман аймаг тугтай өөр мордож яван хүрэв. Хүрээд найман зуун хүүхэд нь, найман хүн мэт болж, найман тугаа хатгав. Найман зуун морио тавих нь, найман зуун хүн ус адрах, гал түлэх аль явдал нь найман хүн мэт явах ажгуу. Хойт найман зуун авчин нь аливаа ан гөрөөс алж, наян согоо алж ирээд мөн урд ёсоор буув. Наян согоогоо гэгээнд өргөж мөргөв. Мөргөхийн цагт нь гэгээн зарлиг болов. Гурван хоногт танай алсан анг нүгэл хилэнц арилгах. Гурав хоноод бас ирж мөргөтүгэй гэв. Гурав хоноод мөргөхдөө хатан хүүхэд нь элдэв өнгийн эд торго нутгаас гэгээний сүм хүртэл дэвсэж түүнийг гишгэн ирж мөргөв. Адис авч, мэндамар хэмээн /3/ гарав. Найман зуун авчин Бүүвэй бэйл тэргүүлэн бүгдээр ирж мөргөхдөө зарим нь ёсоор мөргөж, зарим нь би эцвэй, өвдөв чилэв хэмээмөй. Чи хэр баймөй хэмээн бие биеэсээ асуулцав. Тийн мөргөж байтал Бүүвэй бэйл айлтгав. Зүүн урд зүгт цэрэгт мордох билээ бид. Манд сахиус залж хайр болтугай

---

<sup>3</sup> Хүүхэн гэгээн буюу Хүүхэн хутагт. Халхын Сэцэн хан аймгийн Мэргэн гүний хошуу буюу одоогийн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орон хийдтэй байсан Хүүхэн хутагт хэмээх томоохон ламыг хэлж буй бололтой. Пагмадулам.М, *Хүүхэн хутагтын түүх домог, түүхэн дуу*. УБ, 2014, 185-193; Чин улсын сүүлч үед оросын харьяат хори буриад нар энэ хутагтын хүрээнд ихэд мөргөдөг байсан гэдэг. Позднеев. А.М, *Монголия и монголы*, Том 2. Санкт-Петербург, 1898, 472, 481.

<sup>4</sup> Дундад үеийн хорчин түмний дотор *solongyud* отог байсан ба энд гарч буй *solongyud* нь хорчины *solongyud* болон хожмын Чин улсын үеийн найман хошуунд захирагдсан солон аймагтай ямар холбоотой нь тодорхой бус.

<sup>5</sup> *mo.küler buu*. Үүнийг буу зэвсэг бус харин тамга байж магадгүй гэж бодож байна. Нангиад хэлний 寶 *bao*, манжийн *boobai* буюу эрдэнэ хэмээх нь хааны тамгыг нэрийдсэн үгтэй холбоотой тул Бүүвэй бэйл гэдгийн *büübei* нь ч мөн энэхүү тамгатай холбоотой байж магадгүй.

<sup>6</sup> Хори буриад нарын түүхэнд холбогдсон нэгэн Дай хунтайж буй нь Сэцэн хан Шолойн хүү Анандын 2-р хүү Гонгор дай хунтайж болно. Энэ хүн XVII дунд үед хори буриад нарыг захирч, Оростой идэвхтэй харилцаж байсан билээ. Энд харин солонгудын Бүүвэй бэйл хааны хүү хэмээн тэмдэглэсэн нь хори буриадууд XVII зууны эрт болон дунд үеийн үйл явдлын түүхэн дарааллыг хутгалдуулан өөрийн түүхийг муу цээжилж байсны гэрч гэж үзэлтэй. Дай хунтайжийн тухай, Нацагдорж.Б Цонгоол, *XVII зууны Монгол-Оросын харилцаан дахь харьяатын асуудал*, УБ, 2013, 45-46-д үз.



хэмээн эрэн айлтгав. Тус тустнь сахиус бичиж,байтал нэгэн зуугаадхүн нь сахиус авч байтал хүлээж ядаад энэ бадад ч сахиус юучадвай гэж хэлээд мордож, харьж ирэв. Гэртээ ирээд нэгэн долоон сахиусыг долоон ямаанд зүүгээд тэр долоон ямааг долоон хүн хүмүсэн намнаж ирж харвав. Долоо долоо харватал эс даагдав. Энэ их адистидтай сахиус хүн нэг нэгэн хуудсаар хувааж, найман зуун хүн зүүж, цэрэгт мордов. Мордож очтол хоногчийн газар хүрэхэд ус нь хорхойтой асан тул бие морьгүй ядаж, ууж ядав. Тэр усны цаана утаа гарч очин гэхэд хагас хас биетэй улс байв ажгуу. Түүнийг харваж, цавчиж эс даалгавай. Хоёр зуугаад нь үхэж, буцаж /4/ ирэв.<sup>7</sup> Тийн суутал нь баруун зүгээс Саадагт хэмээх хувилгаан лам ирэв. Түүнд айлтгасанд эртэд

Хүүхэн гэгээний залсан сахиусыг сэргээж засч өгөв. Энэ сахиусаа эвдсэн тул та эс чадав. Аль зүгт асан болов хэмээхэд: - Хол билээ бид эс мэдэв гэв. Саадагт хувилгаан: - Тэд танай гэрийн хойно байна хэмээн нэгэн хүнийг энэ ташуур барьж гараад сүрдэлгүй авч ир гэв. Тэр хүн авч ирж гэрт оруулав. Тэр хувилгаан ном номлож тэд бүхэл биетэй болгож байсан газарт нь илгээв. Тэд бус хааны туршуул гэж зарлиг болов. Тэр газарт хор нь үгүй болов. Та дэмий харь хаан лугаа бүү дайралд хэмээн зарлиг болж, өөд болон харив. Тийн байтал Дай хунтайжид хатан бэдэрч урд зүг мордож Цагаан лусын хаанаас Утаат бүрилэн хэмээх улст хүрч бэрийг хэлэлцэж, тэднийг урьж ирсэн ажгуу. Тэд нь ирж их найр наадам хийж байж бэрээ буулгав. Бүүвэй бэйл эцэг нь Дай хунтайждаа арван отог улс<sup>8</sup> инж өгөв. Тэр хааны хатан нь наснаас өөд болов. Далан дөрвөн настай эцэг хаан бус нэгэн /5/ хатан авав. Дай хунтайжийн Балжин хатан нөхөртөө хэлэв: - Чи энэхэн хатан лугаа инээх наадах чинь энхрэн байнам. Чи самуу муугаар явнам буюу чи гэв. Түүнээс эх бэр хоёр хэрүүлтэй болж, Дай хунтайж нүүж Ононы урдбид Хөхөлбийн хөвчид<sup>9</sup> буув. Тэндээ суутал нь Бүүвэй бэйлийн хатан хаандаа хэлэн уурлав. — Эцэг нь хөвүүнээ мэдэх. Эр нь эмээ мэдэх ёстой. Чи хаан буюу. Хөвүүн чинь эмдээ мэдэгдэж Хөхөлбийн хөвчид

<sup>7</sup> Энэ хэсгийг Балжин хатны домогт: "...yisün sar-a yabuju yeke dalai-du kürged ongyoča-bar yabutala: usun-ača qayas bey-e-tü kümün yarguud: čilayun-iyar sidejü ongyoča-yi ebderegülün olan čerig-i alabai: teden-ü sidegsen čilayun-i tabin kümün ulus ergüjü ese čidabai: teyin ayuju gedergü bučaju yabuqui-dur jam-un usun maγu qorūqai-tai-ača idejü uuyuju yadaju jüderejü jarim ču ükübei" (Позднеев, А.М *Монгольская хрестоматия для первоначального преподавания*. Санкт-Петербург, 1900. 48-49) гэж тэмдэглэсэн бөгөөд Оросын буриадын зарим судлаачид энэ хэсгийг Хубилай хааны усан флот Японыг довтлоод далайн шуурганд сүйрснийг домогжуулан дүрсэлсэн зүйл гэж үзсэн байна. Цыбикдоржиев. Д.В *Великий путь на родину предков*, Прошлое Бурятии. *Этногенез и этническая история*. Улан-Удэ, 2011, 81.

<sup>8</sup> Арван отог улс хэмээх нь Хори буриадын галзууд, хуасай, харгана, хүбдүүд, гучид, шарайд, бодонгууд, батнай, цагаан, худай, халбин отгуудыг хэлж байна. Үүнээс эрт үед гучидийг хори буриадын тоонд оруулан тооцдоггүй байсан тухай Г.Ф.Миллерийн тэмдэглэл байдаг. Долгих, Б.О *Родовой и племенной состав народов Сибири в XVII в.*, Москва, 1960, 331.

<sup>9</sup> Хөхөлбийн хөвч. Одоогийн ОХУ-ын Өвөр Байгалын хязгаарын зүүн өмнө этгээд дэх 140 км урттай далайн төвшнөөс дээш ойролцоогоор 1000-1200 метр өргөгдсөн нуруу. Оросоор Кукульбей хэмээнэ.

гарав гэв. Бүүвэй бэйл уурлаж, хоёр мянган цэргийг илгээв. Балжин хатны баруун хөхийг нь огтолж алаад толгойг нь толгой газар, хөл гарыг нь хөл гар мэт газар орхи. Хар морийг нь нэгэн гол, эмээлийг бус газар тогоог бус газар орхиод Дай хунтайжийг албаттай нь авч ир гэж илгээв. Тэр хоёр мянган цэргүүд очиж дайлахуйд Балжин хатан арван гурван хувилгаантай агсан тул цайвар цасанд хувилж эс /6/ олдов. Албатыг нь аваачих болоход Балжин хатан уснаас өөрөө гарч ирээд хэлэв. — Та эцэг хааны зарлигаар бологтун гэв. Би эцгийн зарлигаас үл давах асан тул чадах боловч би сууж үхмөй гэв. Баруун хөхийг нь огтолж алав. Торойн<sup>10</sup> эхэнд алсан ажгуу. Хааны зарлигаар газар бүгд хувааж орхив. Толгойг нь Балжинын нуураас<sup>11</sup> урд зүгт нэгэн толгойд орхив. Морь нь Бооржийн<sup>12</sup> эхний зүүн биед орхив. Балжинын Хар морьт хэмээх гол болов. Тийн тэр цэргүүд Дай хунтайжийн хоёр мянган арван омог албатыг аваачиж Бүүвэй бэйлд тушаав. Дай хунтайж гэгээнд айлтгав. — Бурханы шажныг наран мэт мандуулагч гэгээнтэн, хааны төрийг баригч эцэг минь. Ану миний явдал юун билээ гэв. Гэгээн зарлиг болов. Эцэг хааныг болиулах Дай хунтайжийг ширээ дартугай гэхэд хөвүүн нь хэлэв. Эцэг минь ширээгээ дартугай. Би хөдөөд сууж нүннэй сахьсу гэв. Гэгээн зөв хэмээж эцэг хаан /7/ ширээндээ суув. Хөвүүн нь нүннэй сахив. Сахихдаа 11 эцэг албат минь тэргүүнд хүрэх цагт үрээр бүү тасартугай. Төрд хүрэх цусанд өөхөөр бүү тасартугай. Нэгэн цагт ламын төрөл олж тандаа өндөр ахуй, өргөн шажин дэлгэж ном номлох минь болтугай хэмээн ерөөл ерөөв. Тэд арван отог албат нь тэндээ байн атал Бүүвэй бэйл хаандаа дургүй тулд нааш цаашаа явж явах[ад] нь бөгтөр хар улиадууд<sup>13</sup> их хорлож алав. Тийн байтал арван отог улсаас зарим отгоос ихэнх нь нааш ирж, заримууд нь баганх нь харьж ирж. Тэр цагт Онон голд Түүргэ<sup>14</sup>, Бооржийн адагт боохой хуасайн<sup>15</sup> Хэхи бөх<sup>16</sup> гэгч долоон настай хөвүүнтэй асан ажгуу. Тэр хөвүүн нь долоон насандаа нохойгоор алагдаж,

<sup>10</sup> Орос-Монголын хил дээр орших давстай Тарь нуурыг хэлсэн бололтой. ОХУ-ын Өвөр Байгалын хязгаар болон Монгол улсын Дорнод аймгийн нутагт хил дамнан оршино. Оросоор Барун-Торей хэмээнэ.

<sup>11</sup> Балжина нуур. Чингис хааны ялагдаж нуугдаж явахдаа итгэлт нөхдийн хамтаар ам алдаж тангарагласан газар гэдэг. ОХУ-ын Өвөр Байгалын хязгаарын Дульдаргын районы нутагт оршино. Оросоор Бальзино хэмээнэ.

<sup>12</sup> Боорж гол. Хөхөлбийн нуруунаас эх авч Онон мөрөнд цутгана. Оросоор Борзя хэмээнэ.

<sup>13</sup> бөгтөр хар улиадууд. Дорнод монголын хамниган, барга нарын дотор байх нэгэн овог. Уг гарал нь монгол бөгөөд Оросын харьяанд орохдоо хамниган ноён Гантимуровын захиргаанд орсон тул хамниган гэгдэх болсон гэдэг.

<sup>14</sup> Түүргэ. ОХУ-ын Өвөр Байгалын хязгаар дахь Онон мөрөнд цутгах гол. Оросоор Турга хэмээнэ.

<sup>15</sup> боохой хуасай. Хори буриадын хуасай отгийн доторх нэг хөхүүр. Сумьяабаатар.Б *Буриадын угийн бичгээс*, УБ, 1966, 32-128-д үзмүү.

<sup>16</sup> Юмсуний Ванданы зохиосон “Хорийн арван нэгэн эцгийн зоны уг язгуурын тууж”-ид Бавж баатарын эцгийг beki vcke Бэхи бөх гэсэн байдаг. Летописи хоринских бурят. Выпуск 1. Хроники Тугултура Тобоева и Вандана Юмсунова, Текст издал Н.Н.Поппе. Ленинград, 1935, 59; Хуасайн угийн бичигт Бавж барс баатарын эцгийг bagim-a menggetь Барим мэнгэт гэдэг. Сумьяабаатар.Б *Буриадын угийн бичгээс*, УБ, 1966, 24.

арьс махаа хага татуулавч гэмгүй явах тийм баатар хүн асан тул нь Бавж барс баатар<sup>17</sup> гэж нэрлэв. Тэр хүн их тамхич асан. Тамхи тасалдаж байтал нь нэг орос тамхи худалдаж ирэв. /8/ Авах юмгүй асан тул сул эрэхэд нь эс өгөв. Тэр оросын мордож очиход тэр баатар хойноос гэтэж очоод яс нуруугаар харваж алаад тамхийг авав.<sup>18</sup> Эцэг нь энэ газар сууж үл болох хэмээн айж нүүж урд зүг дэх ах дүүдээ очив. Тийн байтал бас бус улс: - Би Бавж барс баатар би гэж ирэн ирэн бөгтөр хар улиадад алагдаж байв. Тийн байтлаа Хэхи бөх сөөргөө нүүж мөн Ононд буув. Эцэг эхдээ агнаж гахай алж өгч хоолойг нь тэжээж байв. Тийн байтал Бавж барс баатар нэгэн өдөр агнаад хоёр гахай тэгнэж ирэхэд нь гучаад улиад ирээд отгийг нь буцалж байж хэлэв. Ононы нороог(?) үлдэх буга явна гэхэд бэл бол чөмөгтэй буюу сэрсүр цохьё гэж ирэв бид гэв.<sup>19</sup> Бавж барс баатар хэлэв. Миний арван салаат бэл бол чөмөгтэй. Та буюу үгүй буюу. Нарны галтайд дайралдъя хэмээн харвалдав. Бавж барс баатар зэвийн хүрэх газарт морь алдахгүй. Сумны хүрэх газарт хүн алдахгүй тийм мэргэн баатар асан аж. Гучин улиад харвав эс хүргэв. Барс баатар харвав. Сүүлчийн хүнээс хорин хоёр онь давж хорин хоёр хүнийг унагав. /9/ Найман хүн үлж дутаав. Дутаахад нь гурван хүний морийг харваж авч хүнс аваад тэднийг нэхэж гүйцээд хэлэв. Ухаа морийг минь хөл доголон болтол харвав та. Морины ял янх ац гэхэд нь гурван морь эмээлтэйг өгч: - Бид үүнээс хойш арван нэгэн эцэг<sup>20</sup> танд халгаахгүй. Бидний нэр авч ортугай хэмээн тангараглав. Тэр найман хүн буцаж очив. Тэр цагт арван нэгэн эцгийн зуун жаран саадаг<sup>21</sup> улс болж Нэрчүүгийн<sup>22</sup> зургаанд<sup>23</sup> хорь гучин мөнгө

<sup>17</sup> Хори буриадын түүхэн домогт их гардаг түүхэн хүн. Угийн бичгээс үзвэл XVII дунд хагаст төрж, сүүл хагаст амьдарч явсан хүн бололтой. Сумьяабаатар.Б *Буриадын угийн бичгээс*, УБ, 1966,24; Тойн гүүшийн ах дүү гурванд ирээдүй цагийн дуртгал оршив зохиолд Бавж баатрыг 1699 оны орчим амьд байснаар тэмдэглэсэн буй. Нацагдорж.Б Цонгоол, *XVII зууны Монгол-Оросын харилцаан дахь харьяатын асуудал*, УБ, 2013, 257.

<sup>18</sup> Энэхүү домгийг Б.Сумьяабаатар боохой хуасай Хөхдэй хэмээх С.Мижидээс 1963 онд тэмдэглэж авснаа нийтлүүлжээ. Харин тамхи худалдах гэж ирсэн хүнийг хамниган хүн гэсэн байдаг. Сумьяабаатар.Б *Буриадын угийн бичгээс*, УБ, 232.

<sup>19</sup> Энэ хэсгийн утга балархай байна. Балжин хатны домог дахь үүнтэй холбогдох хэсэгт: "...онон youl uruyudaju arban tabun salayatu ebertei: arjavar sir-a buyu oĭibai genem: tegün-i bel bol ċimege-tei uu ügei uu: qoyin-a-aċa ni qamtuyar nekey-e gekü-yi sonosuyad: babuji bars bayatur: namadu joriysan aji geju mede: quyay duuyuly-a-ban emüsċü numu sumu-ban abun onilayad: ger-tü bayiju ger dotor-a-aċa ügülerün: minu arban tabun salay-a ċimege-tei üü ügei üü: ser surqan ċokilduy-a kemen ger-eċe yarumayċa teden lüge qarbuldun:" гэж тэмдэглэжээ. Позднеев, А.М. *Монгольская хрестоматия для первоначального преподавания*, Санкт-Петербург, 1900, 49.

<sup>20</sup> Хори буриадын 11 отгийг Хоридой мэргэний 11 хүүгийн удам хэмээн домоглох тул хори нар заримдаа өөрсдийгөө 11 эцэг гэж нэрлэдэг.

<sup>21</sup> Нэг саадаг нь нэг цэргийг төлөөлүүлсэн нэгж болно.

<sup>22</sup> Нэрчүү. ОХУ-ын Өвөр Байгалын хязгаарт орших Шилка голд цутгадаг гол. Энэ голын адагт 1658 онд оросууд шивээ байгуулсныг Нерчинск хэмээдэг. Манж, монгол хэлний сурвалжид nibċü Нэвчүү хэмээн тэмдэглэдэг бол оросоор Нерча гэдэг.

<sup>23</sup> Зургаан. Өвөр Байгалын буриад аялгуунд засаг захиргааны газрыг ингэж нэрлэдэг нь манж хэлнээс зээлдсэн jurgan яам, тамгын газар гэсэн утгатай үг болно.

алба өргөж байв. Худайн Эмийн хөвүүн Баахан мэргэн гэгч согоо сүвээлдэж харвав. Арван таван эцэгтэй<sup>24</sup> яршилдан булаалдаад, согоог 61 нумны газар өрөөд хамарыг нь оносон тудсан хүн авах гэв. Арван таван эцгийн хүн нэгдэж эс онов. Баахан мэргэн харваж оноод авав. Түүнээс улам хэрүүлтэй болж өглөөний улаан наранд Нэрчүүгийн Цагаан толгойд ирэх сайн эр тань иртүгэй арван таван эцэг хэмээгээд тарав. Тэр цагт арван нэгэн эцгийн зарим нь Түгнээр<sup>25</sup> даваа гаргаж нүүв. Бавж барс баатар Цагаан толгойд гарах гэж дотроо мяндсан хуяг өмсч, гадуур төмөр хуяг өмсөөд гарав. Зуун гучаад хамнигад ирж буцлав. Арван таван эцгийн цус шалтан ухаа цусч улаан зэвээ дүрж ирэв. Барс баатар харвалдаж, зуун гучин хүнээс жаран хүн үлэгдэв. Тэд улс хэлэлцэв. Энэ ганц хүнийг /10/ эндээ ээрч хоноод өглөө өдөр нь анхаж гараар барьж алья хэмээлдээд хонов. Өглөө өдөр нь Бавж барс баатар хуяг дуулгаа зэвдээ хатгаж өмсгөж орхиод хоёр хүний хоор дундуур мөлхөж гараад ирэв. Нааш Үд<sup>26</sup> газар бүгдээр нүүж ирсэн ажгуу.

Тэндээс Хударт<sup>27</sup> нутаглаж байх цагтаа цагаан эцгийн дууч хуурч хоёр дуулав. — Манай газар татсан мах, тавьсан таваг мэт билээ. Энэ газрын хүн шавар тогоотой, шаазанхай аягатай мангад<sup>28</sup> гэгч гэж дуулав. Тэр цагт Чичин хаа гэгч орос ирж Хэхи бөхөд тамхи уугаад өгч гадаа хөтөлж гарахад нь цагааны дууч шар иштэй хутгаар хатгаж алсан гэлээ. Тэгэх цагт нь: - Энэ хааны оронд суухыг хэлэлцэх гэж гадаа гарсан билээ би. Юунд алав та гэж Хэхи бөх уйлав. Уйлаад энэ газар амар сууж үл болох гэж тэмээт хүн тэмээгээ таваглаж, хониныхоо хошуу бартал, тэмээнийхээ өвдөг баруулж баруун зүгт нүүж явтал, Барс баатар гурван хоногтухаа мэдээгүй их өвдөөд босов. Босоод хэлэв: - Өвөр газар орж нутаглаж үл болох. Энэ газар гурван жил нутаглаж сууя гэж суув. Суугаад Сэлэнгийг уруудаж нүүж явтал дони таяг тулсан оросыг нэгэн хавцгайд /11/ олон учирж түс гэж дуу гармагц тэдний хүн үхнэм.<sup>29</sup> Очиж үзэхэд цустай аж. Арван нэгэн эцэг хэлэлцэв. Энэ цагаан хаандорох гэж явна бид. Албатыг бүү шамш гэхэд нь хорлохоо байв. Тэд хэлэлцэж нүүж ирэн Итанцийн острогт<sup>30</sup> арван нэгэн эцэг хар тугаа тавьж,

<sup>24</sup> Ононы хамниган нарыг 15 эцэг гэж хэлдэг тухай Мишиг.Л Монгол ард улсын зарим нутгийн хамниган аялгууг сурвалжилсан нь, *Монголын судлал*, Том II, УБ, 1960, 186-187-д үзмүү.

<sup>25</sup> Түгнүй гол. ОХУ-ын Өвөр Байгалын хязгаар болон Буриад улсын нутгийг дамнан урдаг гол. Оросоор Тугнуй гэнэ. Цагаан даваа хэмээх нуруунаас эх авдаг нь энд дурдагдаж буй даваа бололтой.

<sup>26</sup> Үд гол. ОХУ-ын Буриад улсын нутгаар зүүнээс баруун тийш урсч Сэлэнгэ мөрөнд цутгах гол. Энэ голын бэлчир дээр оросууд 1666 онд шивээ байгуулсан нь эдүгээгийн Улаан-Үд хот болно. Оросоор Уда хэмээнэ.

<sup>27</sup> Худар. Сэлэнгэ мөрний адаг Байгал нуурт цутгах зүүн эргийн орчмын тал газар. ОХУ-ын Буриад улсын Кабанск районы нутагт буй. Оросоор Кудара хэмээнэ.

<sup>28</sup> mo.mangγud. Буриад аялгуунд үлгэр домгийн амьтан мангасыг мангад хэмээх бөгөөд энэ үгээр оросуудыг зааж байсан нь одоо ч идэвхтэй хэрэглэгдсээр буй. Эвенки нараар уламжлан солон, дагуур манж нар эхний үед оросуудыг лоса гэж нэрлэж байсан нь мөн л мангас, аймшигт амьтан гэсэн утгатай юм.

<sup>29</sup> Энд галт зэвсэг, буутай орос цэрэгтэй тааралдсан тухай өгүүлжээ. Таяг хэмээх нь цахиур бууны тулгуурыг хэлсэн бололтой.

<sup>30</sup> Итанцийн острог. Халхаас дагаж ирсэн хори буриад нараас алба авахын тулд 1679 онд Итанца

хаанаас эцгийн нэг туг авч,<sup>31</sup> арван нэгэн хүнд бариулж гурван жил болоод алба өгч байсан ажгуу. Тэр алба өгч байхын цагт хуасайн Тогтор хэмээх өвгөн Сүдүнэ, Түдүнэ гэж хоёр хөвүүнтэй өвөр газар баруун зүг цагаа сахиж гээгдсэн ажгуу. Тэр өвгөний хоёр гүүгээс нь төрсөн хоёр гунан нь ямарваа бийт байр морьдод эс гартав. Тэр цагт түүн[ий] тэр бэрх морийг авах гэж цаадах монгол нь гурав хоноодцэрэг ирнэм гэж сонсоод хоёр хөвүүдээ ах дүүдээ Худар[т] илгээв. Хоёр морьдоо унаж ирэв. Ирээд хоёр хөвүүн нь ах дүү лүгээ золгов. Хөвүүд нь ирээд хэлэв. — Нэг хоногтявж ирсэн аж бид. Гурав хоноодцэрэг ирэхийг сонсоод эцэг маань морьдоо хэлний /12/ язгуурт гэвнэ хатгаж, өвчин морин мэт болгож байсан билээ. Тэд монгол нуудтүүнийг үзэж дарагдах хэмээн их баясч байна билээ. Манай мордох цагт гэвнээ сугалж аваад илгээсэн. Дөни дунд мордов бид гэв. Тэр үгэнд Хударын арван нэгэн эцгийн улс жараад саадаг цуглаж зуугаад адуунд хартганад дээл өмсгөж эмээл тохож гүйлгээд Хударын цагаан хөтөлд байлгав. Тийн атал гурав хоноод тэр хөтлөөр монгол цэрэг ирэв. Тэдний өмнөөс зуун агтыг үлдэв. Гуч гучин хүн хоёр захаас нь дав гэв. Тэгэхэд монгол цэрэг гэдрэг тэргэлэв.<sup>32</sup>

Сэлэнгэ далайн олом хүртэл үлдэж далайн олноор гарч одов. Арван нэгэн эцэг буцаж ирээд нутагтаа харуул харж байтал туршуул явсан улс харав. Сэлэнгэ дээр утаа гарч байхыг хараад цэрэглэн ирж үзэхэд хоёр гэргэд нэг согоо барьж идэж сууна аж. Хошингодоо сугандаа амайж суув. — Та юун билээ гэхэд Сүдүнэ, Түдүнэ хоёрын гэргэд билээ. Хоёр гүүгээ унаж ирсэн билээ бид. Хоёр гүүгээ алдаж орхиод: - Цэргийн мөрөөр очигтун гэж эцэг хэлсэн үгээр ирэн гэхэд маань энэ согоог чоно барьсныг идэж байна бид гэв. Сүдүнэ, Түдүнэ хоёр эрс тань энд байнам гэж авч ирээд эрсээр нийлдүүлж суулгав. Жарган суув. Тэр хоёр[т] их /13/ ав бугад үнэг чоно болон аль ихийг зоноос гаргаж өгөх аж. Арван нэгэн эцэг тэр цагт Ойхонд<sup>33</sup> Хударт суух асан аж. Тэр цагт цагаан [эцгийн] Цагаадай баян гэгч Нарийн далайн<sup>34</sup> нуур цагт хусан уургыг гурав хэмжиж адуугаа усалж явав. Тийн явталаа тэр баян найман гүүг үүцэлж Ойхоны чулууны хөндийд хадгалав. Адуу нь чононд идэгдэх тусам хишиггүй болж их цөөн болов. Адгуусны гарзыг нэг үүч хүнд үзэл үзүүлэн гэхэд, - Их ноёдын сүмд мах хадгалсан аж. Чи түүнийг хүндэл гэв. Нэгэн бөө хүнийг учирж үлсэн ганц мориор хатгуур барьж мөргөв. Тэр бөө онгоо оруулаад: - Хар буурын хархирах

---

голын адагт байгуулсан шивээ.

<sup>31</sup> Хори буриад нарт Оросын захиргаанаас отгийн тоогоор туг олгосон нь хожим 1728 онд Буурын гэрээг тогтоосны сүүлээр болсон хэрэг юм. ИМБиТ БНЦ СО РАН, Отдел письменности востока. Инв.№63. Из дела о сибирских братских калмыках (Архив коллегии иностранных дел. 1762-1770 кн.1), 113.

<sup>32</sup> Буцаж зугтав гэсэн утгатай үг.

<sup>33</sup> Ойхон арал. Байгал нуурын дунд орших арал. Оросоор Ольхон хэмээнэ.

<sup>34</sup> Нарийн далай. Байгал нуурын баруун эрэг болон Ойхон арлын дундах хэсгийг ингэж нэрлэдэг. Оросоор Малое море хэмээмү.

бүү үзэгд. Ханан унианы хангинах бүү үзэгд. Хан содноён<sup>35</sup> гэгч би гэж оруулав. Түүнээс улам бусаднь мөргөл хийж догшин ноёдодухаа адгуусаар мөргөв. Тэндээс наашаа мөн Хударт ирж суув. Ойхон гэгч уул догшин хүү хэцүү гэж ирсэн аж. Тийн Сэлэнгээр нутагласан бөлгөө. Түгнэ, Үд, Ага<sup>36</sup>, Ингидэйгээр<sup>37</sup> нутаглав. Тийн байтал эзэн хаанаас Федор Алексеевич гүн Сава<sup>38</sup> хэмээх ноён ирж жаран хоёр овоо<sup>39</sup>, партийн<sup>40</sup> тавин хасаг байгуулан тавив. Тийн Федор Алексеевич овоо тавих цагт өвөр газар /14/ -ын амбан нар нэг оросын байн шээхэд хэлэв. — Ядахгүй бөгөөд нөхөртөө үл өгөлцөх, яарахгүй бөгөөд байн шээх тань юу вэ гэв. Федор Алексеевичийн амбан нарыг их боож хэлэхэд нь, - Таны үгийг хүн харж үл боо. Гүн Сава хэлэв. — Тэр цагт арван нэгэн эцэгт дөрвөн шүүлэнгэ хэргэмтэй хүн буй асан аж. Тийн атал галзуудын Болтирогийн хөвүүн Шодо гэгчийг Федор Алексеевич шинжиж хаан язгууртай их сайхан шинжтэй хүн асан тулд нь тайшаа хэргэмтэй болгов.<sup>41</sup> Түүнээс хойш 11 эцэг амар жаргалантай болж суусан хэмээн эртний өвгөд өгүүлэлдсэн бөлгөө. Тэр цагт арван нэгэн эцгийн ахлагч тайшаа Шодо захиа илгээв. Өвөр газар тасарч гээгдсэн арван нэгэн эцгийн Шилдэй занги<sup>42</sup> гэгчид: - Бид энэ газраар овоо хил тавьж байна бид.

Та нааш орж ирэгтүн гэв. Тэгэхэд нь: - Түгнэ гэгч газар суганы өрөөл, Үд гэгч газар тань дээл[ийн] өрөөсөн ханцуй мэт газар билээ. Морь ядваас жороо харыг аваачиж уна. Эмээл ядваас алтан эмээл аваачиж тох гэв. Федор Алексеевич түүнийг сонсоод зарлиг болов. Жороо хар, Алтан эмээл гэгч хоёр хадыг нааш оруулж автугай гэсэн үг биш үү хэмээгээд /15/ амбан нартай их хэлэлцэж ядаад энэ манай газар гэж Алтан эмээл гэгчийн өвөрт хонин цагаан чулуунд бичиг бичиж орхив<sup>43</sup>. Тэр овооноос цааш зуун жаран модны газар аж. Түүнийг эдүгээ болтол булаалдсаар байх биш үү. Эртэд явагч боохой хуасайн

<sup>35</sup> Буриад бөөгийн тамлагад дурдагддаг Арын 13 ноёдын ахлагч Хан хото ноён мо. qan sutu noyan гэдэг нь Ойхон арлын эзэн бүргэд шувуун дүртэй гэдэг.

<sup>36</sup> Ага. ОХУ-ын Өвөр Байгалын хязгаарт орших нутаг.

<sup>37</sup> Ингидэй гол. ОХУ-ын Өвөр Байгалын хязгаар дахь Хэнтийн нуруунаас эх аван зүүн зүг урсч Онон мөрөнд цутгаж Шилка голыг үүсгэдэг. Оросоор Ингода хэмээнэ.

<sup>38</sup> Энд Чин улстай 1689 онд Нэвчүүгийн гэрээг тогтоож Эргүнэ мөрнөөс зүүн тийших хил хязгаарыг баталсан Федор Алексеевич Головин болон 1727 онд Буурын гэрээг байгуулж Эргүнэ мөрнөөс Зүүнгарын хил хүртэл Чин улстай хил тогтоосон Сава Владиславич Рагузинский хоёрыг нэг хүн болгон хутгажээ.

<sup>39</sup> Орос Чингийн хилийн дагуу босгосон нийт овооны тоог хэлж байна.

<sup>40</sup> Партия. Хилийн харуулын цэргийг хэсэг бүлгээр илгээхийг ингэж нэрлэдэг.

<sup>41</sup> Хори буриадын галзууд отгийн Болтирогийн Шодо нь Буурын гэрээг байгуулж хил тогтооход идэвхтэй хүчин зүтгэж явсан тул Сава Владиславич Рагузинскийн саналаар 1729 онд Оросын хааны зарлигаар тайша хэргэмд батлагджээ. *Историческая записка о Китайской границе, составленная советником Троицко-Савского пограничного правления Сычевским в 1841 году*, Москва, 1873, 114.

<sup>42</sup> Халхын Сэцэн хан аймгийн бэйс Янжувдоржийн хошууны харьяат барга сумны занги. 1730 онд Орост харьяат сумныхаа ардыг дагуулан оргож ороод Буурын гэрээний дагуу Чин улсын талд буцаагдаж хил дээр цаазлагдсан хүн.

<sup>43</sup> Бичигт цагаан чулуу. Хожим XX зууны эхэнд хори буриад нар Монголын зүг нүүдэллэхэд Бичигт цагаан чулууг хүртэл нүүж суурьших тухай Молон багш гэгчийн лүндэнг эш болгон явсан гэдэг.



Бавж барс баатарын ач үр эдүгээ Далдатын хөвүүн Мэргэн барду гэгч бөлгөө. Хандад Иван тайшаад буй. Тогторын ач үр эдүгээ Хүрбэ<sup>44</sup> ойбундын дотор зүүн хуасай нар буй биш үү. Эртний өвгөдийн байгуулсан шастир тууж төгсөв. Ом мани бадмэ хум. Ом мани бадмэ хум.

### Дүгнэлт

А.М.Позднеевийн хэвлүүлсэн *Балжин хатны домог*-оос ялгаатай нь Бавж барс баатар тэргүүтэй босгуулууд Байгал нуурын зүүн эрэг Сэлэнгэ мөрний адаг, Худрын талд хүрч Оросын цагаан хаанд дагах гэсэн боловч эхний тааралдсан оросыг алж орхисноос хэрэг бүтэмжгүй болж, цаашлан нүүж явахдаа оросын цэрэгтэй учирж галт зэвсгийн хүчинд автан бууж өгч дагаар орсон; Орос-Чингийн хооронд хил тогтоох үед Чингийн талд тасарч хоцорсон “ах дүү” нараа нутагтай нь цуг авахын тулд тавьсан хилээс урагш 160 модны газарт цагаан чулуун дээр бичиг бичүүлж гэрч болгохоор чармайсан нь бүтэмжгүй болсон гэх мэт мэдээнүүд энэ эхэд харагдаж байна.

Энд дурдагдаж буй хоёрдахь мэдээ нь нилээд сонирхолтой юм. Хожим ХХ зууны эхэнд Оросын харьяат буриад нар нийгэм улс төрийн олон шалтгаанаас үүдэн Ар Монголын зүг олноор нүүдэллэн ороход сэтгэл санааны хувьд их нөлөөлсөн гэж үздэг *Молон багийн лүндэн* гэдэгт Монгол газар дахь Бичигт цагаан чулууг өнгөртөл нүүж очвол сая амар амгалан амьдралтай золгоно гэсэн үг байдаг нь энд дурдагдсан бичигтэй цагаан чулууг гэдэгтэй холбогдох бололтой.<sup>45</sup> Хил тогтоох үед тэмдэглэн үлдээсэн тэрхүү нутаг нь хори буриад нарын хуучин нутаг, ах дүү нар нь үлдсэн газрыг тэмдэглэсэн тул тэр нутгаас урагшаа нүүж очвол хойноосоо нэхэгдэхгүй, амар жаргалтай амьдарч болох тухай өгүүлэмж хори буриад нарын дэлгэрч байсан гэж үзэж болох юм.

**Abstract:** The author introduces the transliteration of the unpublished version of the earliest Khori-Buryat ‘chronicle’ named *Bübei bevelü-yin sudur orošiba*, kept at the National Library of Mongolia.

---

<sup>44</sup> Хүрбэ гол. ОХУ-ын Буриад улсын нутагт орших Үд голд цутгадаг гол. Оросоор Курба хэмээнэ.

<sup>45</sup> Энэ бичигтэй цагаан чулууг хаана байгаа тухай эрэл хийсэн М.Одмандахын тэмдэглэл бий. Одмандах М. Бичигт цагаан чулууны эрэлд, *Буриад судлал* №4, УБ, 2014, 149-165.